



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ИНДЕКС

Боловсруулсан: ССХ-гийн ЭЗСШСХ-ийн
эдийн засагч

А.Төгөлдөр

2026 оны 03 дугаар сар

Агуулга

1. Удиртгал	3
2. Онолын арга зүй.....	3
3. Монгол Улсын эдийн засгийн гүйцэтгэлийн индекс	5
3.1. Бүрэлдэхүүн үзүүлэлтүүд	5
3.2. Үзүүлэлтүүдийн өнөөгийн байдал.....	6
3.3. Бенчмарк буюу жишиг утга.....	11
3.4. Эдийн засгийн гүйцэтгэлийн индекс.....	12
4. Дүгнэлт	15
Ашигласан материал	18

Зураг, хүснэгтийн жагсаалт

Зураг 1. Эдийн засгийн өсөлт ба инфляц	7
Зураг 2. Төсвийн тэнцэл.....	8
Зураг 3. Урсгал дансны тэнцэл.....	9
Зураг 4. Зээл	10
Зураг 5. Гадаад өр	11
Зураг 6. Эдийн засгийн гүйцэтгэлийн индекс	12
Зураг 7. Эдийн засгийн гүйцэтгэлийн индекс, бүрэлдэхүүн үзүүлэлтээр	13
Зураг 8. Эдийн засгийн гүйцэтгэлийн индекс (гадаад өрийг оруулсан)	15
Хүснэгт 1. Эдийн засгийн гүйцэтгэлийн индексийн онооны систем.....	5

1. Удиртгал

Энэхүү судалгаа, шинжилгээний ажлаар Монгол Улсын эдийн засгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг ашиглан индекс тооцож, үнэлэхийг зорилоо.

Эдийн засгийн нөхцөл байдал, гүйцэтгэлийг үнэлэх хамгийн энгийн бөгөөд өргөн ашиглагддаг арга нь ДНБ эсвэл нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлтөд шинжилгээ хийх явдал юм. Гэхдээ зөвхөн ДНБ-ий өсөлтөөр нийт эдийн засгийн нөхцөл байдлыг дүгнэх, макро эдийн засгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг хэмжих нь учир дутагдалтай тул олон үзүүлэлтүүдийг ашиглан энгийн бөгөөд хялбар аргачлалаар индекс тооцож судалгаа, шинжилгээнд ашиглах нь үр дүнтэй байдаг. Khramov болон Lee (2013) нар АНУ-ын эдийн засгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэхдээ Economic Performance Index буюу Эдийн засгийн гүйцэтгэлийн индекс (ЭЗГИ)-г ашигласан бөгөөд энэхүү судалгааны ажлаар ЭЗГИ нь улс орны ерөнхий макро эдийн засгийн гүйцэтгэлийг арга зүйн хувьд энгийн, хялбар байдлаар үнэлэх боломжтойг харуулсан.

ЭЗГИ нь бүтцийн хувьд энгийн бөгөөд эдийн засгийн үндсэн 3 сектор болох өрх, үйлдвэрлэгч болон засгийн газрын үйл ажиллагааны гүйцэтгэлийг хэмждэг макро эдийн засгийн үзүүлэлт юм. ЭЗГИ нь дээрх 3 секторт нэгэн зэрэг нөлөөлж болохуйц хувьсагчдаас бүрддэг. Үүнд (i) инфляцын түвшин – мөнгөний бодлогын эдийн засагт үзүүлэх үр нөлөөг хэмжих үзүүлэлт; (ii) ажилгүйдлийн түвшин – үйлдвэрлэлийн нөхцөл байдлыг хэмжих үзүүлэлт; (iii) төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь – төсвийн бодлогын эдийн засагт үзүүлэх үр нөлөөг хэмжих үзүүлэлт; (iv) бодит ДНБ-ий өсөлт – нийт эдийн засгийн байдлыг хэмжих үзүүлэлт.

ДНБ эсвэл нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлтөд шинжилгээ хийж эдийн засгийн нөхцөл байдлыг үнэлэх нь хамгийн энгийн бөгөөд түгээмэл арга юм. Гэхдээ зөвхөн ДНБ-ий өсөлтөөр нийт эдийн засгийн нөхцөл байдлыг дүгнэх нь хангалттай биш тул олон хувьсагчдыг багтаасан цогц индексүүдийг тооцож судалгаа, шинжилгээнд ашиглаж байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг хэмжих индексүүд нь зарим тохиолдолд хэтэрхий олон хувьсагчдыг агуулсан байдаг тул тухайн индексээс хэрэгтэй мэдээллээ олж харахад төвөгтэй байдаг. Мөн тэдгээр индекс нь эконометрикийн аргачлалд суурилсан байдаг нь олон нийт болон төрийн бодлого боловсруулагчид ойлгоход хүндрэл тулгардаг байна. Тиймээс ОУВС-гаас нийт эдийн засгийн ерөнхий гүйцэтгэлийг үнэлэх нэгэн энгийн индексийг шинээр тооцож гаргасан бөгөөд энэ нь олон нийт ойлгоход хялбар болж, төрийн бодлого боловсруулагчид энэхүү индексийг ашиглан эдийн засгийн нөхцөл байдлын талаар бие даасан үнэлгээг өгөх боломжтой болсон байна.

2. Онолын арга зүй

ЭЗГИ нь макро эдийн засгийн үзүүлэлт бөгөөд тухайн улсын эдийн засгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг хэмжиж, зорилтот түвшнээс хазайх хазайлтыг мэдээлдэг хэмжигдэхүүн юм. ЭЗГИ нь эдийн засгийн үндсэн 3 сектор болох өрх гэр, үйлдвэрлэгч аж ахуйн нэгж болон засгийн газрын эдийн засгийн үйл ажиллагааг тусгадаг бөгөөд эдгээр 3 секторт нэгэн зэрэг нөлөөлж болохуйц хувьсагчдаас бүрддэг.

- Инфляцын түвшин – мөнгөний бодлогын эдийн засагт үзүүлэх үр нөлөөг хэмжих үзүүлэлт;

- Ажилгүйдлийн түвшин – үйлдвэрлэлийн нөхцөл байдлыг хэмжих үзүүлэлт;
- Төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь – төсвийн бодлогын эдийн засагт үзүүлэх үр нөлөөг хэмжих үзүүлэлт;
- Бодит ДНБ-ий өсөлт – нийт эдийн засгийн байдлыг хэмжих үзүүлэлт.

ЭЗГИ тооцоход ашиглагдсан хувьсагчид дараах байдлаар индексийн утгад нөлөөлнө:

- Инфляц зорилтот түвшнээс хазайхад индексийн утга буурна.
- Ажилгүйдэл зорилтот түвшнээс давбал индексийн утга буурна.
- Төсвийн алдагдал зорилтот түвшнээс давбал индексийн утга буурна.
- Бодит ДНБ-ий өсөлт зорилтот түвшнээс давсан үед индексийн утга өснө.

ЭЗГИ-г жилийн, улирлын болон сарын давтамжтай тооцох боломжтой бөгөөд нийт оноо болох 100 хувиас үзүүлэлт бүрийн бенчмарк¹ буюу жишиг утгаас инфляцын түвшин, ажилгүйдлийн түвшин, төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувийг хасаж бодит ДНБ-ий өсөлтийн хувийг нэмж тооцох ба эдгээр хувьсагчдын индекс тооцоход ашиглах хувийн жинг зорилтот түвшнээс хазайх хазайлтад үндэслэн тооцно. Энэхүү аргачлал нь эдийн засгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг улсын хэмжээнд эсвэл бүсийн болон олон улсын түвшинд хэмжихэд үр дүнтэй байдаг. Үүнийг томъёо хэлбэрээр илэрхийлбэл дараах байдалтай байна.

$$EPI = 100\% - w_{inf} |Inf(\%) - I^*| - w_{unem} (Unem(\%) - U^*) - w_{Def} \left(\frac{Def}{GDP} (\%) - \frac{Def^*}{GDP^*} \right) + w_{GDP} (\Delta GDP(\%) - \Delta GDP^*) \quad (1)$$

Энд: *-оор тэмдэглэсэн нь үзүүлэлтүүдийн бенчмарк;

Inf - инфляц;

U - ажилгүйдлийн түвшин;

Def/GDP- төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь;

ΔGDP- бодит ДНБ-ий өсөлт;

w_i – хувьсагч бүрийн хувийн жин бөгөөд дараах томъёогоор тооцно.

$$w_i = \frac{1}{StD_i} * StDev_{Av} \quad (2)$$

Энд: StD_i нь хувьсагч бүрийн стандарт хазайлт, $StDev_{Av}$ нь хувьсагч бүрийн стандарт хазайлтын дундаж.

$$StDev_{Av} = \frac{1}{4} \sum_{i=1}^4 StD_i \quad (3)$$

¹ Бенчмаркыг сонгохдоо үзүүлэлт бүрийн эдийн засгийн утгыг харгалзан үзэж онолын болон практик түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн оновчтой буюу зорилтот түвшинг авч үзнэ.

Индексийн утгыг олон нийтэд илүү ойлгомжтой болгох үүднээс энгийн онооны системээр босго утгыг тогтоож үнэлгээ хийх боломжтой болсон (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Эдийн засгийн гүйцэтгэлийн индексийн онооны систем

Онооны интервал	Оноо	Дүн	Эдийн засгийн гүйцэтгэл
95-100	≥99	A+	Маш сайн
	96-99	A	
	95-96	A-	
90-95	94-95	B+	Сайн
	91-94	B	
	90-91	B-	
80-90	87-90	C+	Дундаж
	83-87	C	
	80-83	C-	
60-80	74-80	D+	Муу
	66-74	D	
	60-66	D-	
60-с доош	<60	F	Маш муу

Эх сурвалж: ОУВС

ЭЗГИ-ийн утга 95-100 хооронд байвал “маш сайн”, 90-95 хооронд байвал “сайн”, 80-90 хооронд байвал “дунд”, 60-80 хооронд байвал “муу”, 60-аас доош гарвал “маш муу” гэсэн үнэлгээг өгнө.

3. Монгол Улсын эдийн засгийн гүйцэтгэлийн индекс

3.1. Бүрэлдэхүүн үзүүлэлтүүд

Khramov болон Lee (2013) нар ЭЗГИ-ийг тооцоходоо эдийн засгийн үндсэн гурван сектор (өрх гэр, үйлдвэрлэгч болон засгийн газар)-ын үйл ажиллагааг хэмжих үзүүлэлтүүдийг ашигласан бөгөөд үүнд ДНБ-ий өсөлт, инфляц, ажилгүйдлийн түвшин болон төсвийн тэнцэл гэсэн 4 үзүүлэлт багтсан байна.

Монгол Улсын ЭЗГИ-ийг тооцоходоо дээрх 4 үндсэн үзүүлэлтүүдээс (ажилгүйдлийн түвшнийг хассан) гадна манай орны эдийн засгийн онцлогийг харгалзан үзэж нэмэлт үзүүлэлтүүдийг оруулж тооцсон. Тодруулбал (i) эдийн засгийн өсөлт, (ii) инфляц, (iii) төсвийн тэнцэл, (iv) урсгал дансны тэнцэл, (v) зээлийн хэмжээ гэсэн үзүүлэлтүүдийг ашиглан ОУВС-гийн боловсруулсан аргачлалын дагуу ЭЗГИ-ийг тооцоолсон.

Монгол Улс нь АНУ-тай харьцуулахад жижиг бөгөөд нээлттэй эдийн засагтай тул макро эдийн засгийн үзүүлэлтүүд нь гадаад эдийн засгаас өндөр хамааралтай байдаг. Ялангуяа эдийн засагт чухал ач холбогдолтой гадаад худалдааны үзүүлэлт нь дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнээс шууд хамааралтай байдаг байна. Тиймээс төлбөрийн тэнцлийн статистикаас урсгал дансны тэнцлийн ДНБ-д эзлэх хувийг нэмэлт үзүүлэлт болгон индексийн тооцоонд оруулсан. Урсгал дансны тэнцэл нь тухайн улсын бусад улс орнуудтай хийсэн гүйлгээ болон дотоод эдийн засгийн хөрөнгө оруулалтын позицод гарсан өөрчлөлтийг харуулдаг үзүүлэлт юм.

Дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал санхүүгийн секторт тэнцвэргүй байдал үүсэх нь эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлдэг болохыг харуулсан. Garry болон Francisco (2016) нарын судалгаанд Латин Америкийн ЭЗГИ-ийг тооцохдоо санхүүгийн секторыг төлөөлүүлж банкны салбарын хувийн хэвшилд олгосон зээлийг авч үзсэн байна. Учир нь ихэнх санхүүгийн хямралууд нь хэт их хэмжээний зээл олголтоос үүдэлтэй байсан байна. Монгол Улсын хувьд санхүүгийн сектор, тэр дундаа банкны салбарын эдийн засагт үзүүлэх нөлөө нэлээдгүй өндөр тул тус салбарын нөхцөл байдлыг илэрхийлэх үзүүлэлтийг индексийн тооцоонд зайлшгүй оруулах шаардлагатай юм. Тиймээс энэхүү судалгаанд Монгол Улсын иргэд, улсын болон хувийн хэвшилд олгосон нийт зээлийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувийн өөрчлөлтийг индексийн тооцоонд оруулсан.

Засгийн газрын тайлан тэнцэл буюу төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувийг индексийн тооцоонд оруулсан бөгөөд энэхүү үзүүлэлт нь төсвийн санхүүгийн урт хугацааны тогтвортой байдлыг үнэлэхэд хамгийн түгээмэл хэрэглэгддэг үзүүлэлт юм. Түүнчлэн манай улсын эдийн засагт засгийн газрын оролцоо харьцангуй өндөр байдаг бөгөөд төсвийн бодлогын эдийн засгийн гүйцэтгэлд үзүүлэх нөлөө их байдаг тул төсвийн тэнцлийн үзүүлэлтийг индексийн тооцоонд оруулж тооцов.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын гадаад өрийн хэмжээ өндөр түвшинд хүрч, үүний эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөө өсөж байна. Хэдийгээр 2018 оноос эдийн засаг сэргэж, макро эдийн засгийн үзүүлэлтүүд сайжирч байгаа ч гадаад өрийн хэмжээ өндөр хэвээр байгаа нь цаашид эдийн засгийн үйл ажиллагааны гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх эрсдэл өндөр хэвээр байгааг илтгэж байна. Тиймээс Монгол Улсын ЭЗГИ-ийг нийт гадаад өрийн ДНБ-д эзлэх хувийг нэмэлт үзүүлэлт болгон оруулж алтернатив хувилбараар тооцож, гарсан үр дүнг анхны индекстэй харьцуулж дүгнэлт хийсэн.

3.2. Үзүүлэлтүүдийн өнөөгийн байдал

Эдийн засгийн өсөлт: 1990-ээд оны эхэнд эдийн засгийн байдал хүндэрч улмаар 1992 онд эдийн засгийн өсөлт хамгийн доод түвшиндээ буюу сөрөг 9.3%-д хүрч байв. 1994 оноос эхлэн төр засгийн зүгээс эдийн засгийн бодлогын хүрээнд хэд хэдэн томоохон арга хэмжээ авч ажилласны үр дүнд эдийн засаг сэргэж тогтворжих хандлагатай болсон бөгөөд бодит ДНБ 2000 он хүртэл жилд дунджаар 3.2%-ийн өсөлттэй байжээ.

Эдийн засгийн өсөлт 2000 онд саарч 1.1% болсон бол 2003 оноос дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ өсөж эдийн засгийн өсөлт эрчимжиж эхэлсэн байна. 2004-2007 онуудад бодит ДНБ жилийн дундаж өсөлт 9.2%-тай байсан бөгөөд энэхүү эдийн засгийн өндөр өсөлтийн ихэнхийг нь уул уурхайн салбар бүрдүүлж байв.

Дэлхийн санхүү, эдийн засгийн 2008-2009 оны хямрал манай улсын эдийн засагт сөргөөр нөлөөлж бодит ДНБ-ий өсөлт -1.3% болж огцом буурсан байна. Харин 2010 оноос

хямралын нөлөө саарч эдийн засаг дахин сэргэж эхэлсэн байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ, ялангуяа уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт огцом нэмэгдэж эдийн засгийн өсөлтийг хурдасгасан байна. Улмаар 2011 онд эдийн засгийн өсөлт түүхэнд байгаагүй хамгийн өндөр түвшин буюу 17.3 хувьд хүрч 2013 оноос өсөлтийн хурдац саарсан нь уул уурхайн салбарт орох хөрөнгө оруулалт огцом буурсантай холбоотой байна. 2014 оноос манай орны бодит ДНБ-ий өсөлт гадаад сөрөг хүчин зүйлсээс шалтгаалан буурсаар 2016 онд 1.5% болсон. 2017 оны сүүл үеэс 2019 хүртэл сэргэж байсан эдийн засаг 2020 оны цар тахлын улмаас -4.6%-д хүрэв. 2021 оноос эхлэн хямралын нөлөө саарч 2025 оны байдлаар ДНБ-ий өсөлт 6.8%-д хүрээд байна.

Зураг 1. Эдийн засгийн өсөлт ба инфляц



Эх сурвалж: ҮСХ

Инфляц: Шилжилтийн эхний жилүүдэд манай улс гиперинфляцтай байсан бол Монголбанкнаас мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлж инфляцын түвшнийг 1998 он гэхэд 9.5%, улмаар 1999 онд нэг оронтой тоонд буюу 7.6% хүртэл бууруулжээ.


2000-2004 оны хооронд жилийн дундаж инфляц 6.5% орчимд тогтвортой байсан бол 2005 онд шатахууны дэлхийн зах зээлийн үнэ өссөнөөр 12.7%-д хүрсэн байна. 2008 онд импортын гол бараа, бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ өссөн, төсвийн тэлэх бодлогыг явуулсан зэрэг шалтгаан нь 2006, 2007 онуудад нам дор түвшинд, тогтвортой байсан инфляцыг 4-5 дахин өсгөж 28%-д хүргэсэн байна.

2009 оны дэлхийн санхүү эдийн засгийн хямралын улмаас манай эдийн засаг зогсонги байдалд орсноор үнийн өсөлт буурсан бол 2010-2013 оны хооронд төсвийн тэлэх бодлого болон нийлүүлэлтийн талын хүчин зүйлсээс шалтгаалан инфляц эргээд өсөж 10-14%-д хүрч байв. 2013 оноос эдийн засгийн идэвхжил буурч, царцанги байдалд орсноос шалтгаалан инфляц нам дор түвшинд байсан. Инфляцын түвшин 2022 онд 14.6%, 2023 онд 10.4%, 2025 онд 8.6% тус тус гарчээ.

Төсвийн тэнцэл: Улсын нэгдсэн төсвийн тэнцэл 1992-1993 болон 1995-1996 онуудад бага зэрэг ашигтай гарсан бол 1994 онд алдагдал нь ДНБ-ий 2.6 хувьд хүрчээ. Харин 1997-1998 онуудад төсвийн алдагдал үлэмж хэмжээгээр нэмэгдэж, ДНБ-ий 7-10 хувьтай тэнцэхээр

болсон байна. Алдагдал ийнхүү өссөн нь төсвийн орлого, зарлагыг тооцох аргачлал өөрчлөгдсөнтэй холбоотой ч нөгөө талаар эдийн засгийн гадаад байдал муудсанаас томоохон аж ахуйн нэгжүүдийн орлого тасарсантай холбоотой юм.

Зураг 2. Төсвийн тэнцэл




Эх сурвалж: ҮСХ

2000-2004 онуудад улсын төсвийн орлогын тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэх, үр ашиггүй зардлыг хязгаарлахад анхаарч ажиллаж ирсэн хэдий ч төсвийн алдагдал өндөр хэвээр ДНБ-ий 5.2%-тай тэнцэж байв. 2005-2007 онуудад экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ өндөр өсөлттэй байсан нь төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлж төсвийн тэнцэл ДНБ-ий 2.7%-тай тэнцэх хэмжээний ашигтай байжээ.

2008-2009 оны хямралын үед төсвийн тэнцэл эргээд алдагдалтай болсон бол 2010 оноос эдийн засгийн нөхцөл байдал сэргэж, үйлдвэрлэл нэмэгдэж, экспорт өссөн нь татварын орлогыг өсгөх таатай нөхцөлийг бий болгон, төсвийн алдагдал буурсан байна. Гэсэн ч 2011 оноос төсвийн зарлагыг нэмэгдүүлж эхэлсэн бөгөөд 2016 он гэхэд төсвийн тэнцэл хамгийн доод түвшинд хүрч ДНБ-ий -15.3%-тай тэнцсэн юм. 2017 оноос Монгол Улс ОУВС-тай хамтран хэрэгжүүлж эхэлсэн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд төсвийн сахилга батыг хангаж, зарлагыг бууруулах чиглэлд бодлого хэрэгжүүлснээр төсвийн алдагдлыг бууруулж 2018 онд 27.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 0.09%-тай тэнцэх ашигтай, 2019 онд -2%-тай гарсан бол 2020 онд 2016 оноос хойших өндөр алдагдалтай жил буюу -11.9%-тай гарсан байна. Харин 2021 онд төсвийн тэнцэл ДНБ-ий -6.7%-тай тэнцэж байсан бол сүүлийн жилүүдэд “Төрийн хэмнэлтийн тухай” хууль баталж, төсвийн зарлагыг тодорхой хэмжээгээр бууруулснаар нөхцөл байдал сайжирч 2024 онд -1.2%-тай гарсан бол 2025 оны байдлаар -1.4%-тай тэнцэх алдагдалтай гарсан байна.

Урсгал данс: Манай улсын төлбөрийн тэнцлийн урсгал дансны хувьд 1993-2000 оны хооронд харьцангуй тогтвортой байсан ба жилд дунджаар ДНБ-ий 0.3%-тай тэнцэх алдагдалтай байв.

Зураг 3. Урсгал дансны тэнцэл




Эх сурвалж: Монголбанк

Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ 2003 оноос өсөж эхэлснээр 2004-2007 онуудад манай улсын урсгал данс ашигтай гарч байжээ. Эдийн засгийн халалт, төсвийн огцом тэлэлт, импортын өсөлттэй уялдан 2008 онд урсгал тэнцлийн алдагдал нэмэгдэж ДНБ-ий 12.3%-д хүрсэн байна. Түүнчлэн гадаадын шууд хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн тоног төхөөрөмжийн импортын өсөлтөөс шалтгаалж урсгал тэнцлийн алдагдал 2012 онд хамгийн дээд түвшин буюу ДНБ-ий 43.8%-д хүрэв.

2014 оноос гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) зогсож, уул уурхайн хөрөнгө оруулалт багасан машин механизм, тоног төхөөрөмжийн импорт буурснаар урсгал дансны алдагдал буурсан. Гэсэн ч экспорт буурч, хэрэглээний бусад бараа, бүтээгдэхүүний импорт өссөнөөр урсгал дансны алдагдал тодорхой хэмжээнд байсаар байв. 2016-2018 онуудад манай улсад уул уурхайн бүтээн байгуулалттай холбоотой ГШХО хийгдсэнээр тоног төхөөрөмжийн импорт өсөж урсгал дансны алдагдал өссөн бөгөөд 2018 оны байдлаар ДНБ-ий 16.7%-тай, 2019 онд 15.2%-тай тэнцүү гарсан байна. Харин 2020 онд -5.1%-тай, 2021 онд -13.8%-тай, 2022 онд -13.5%-тай гарсан бол 2023 онд 0.6%-тай ашигтай гарсан ч, 2025 онд ДНБ-ий 4.5%-тай тэнцэх хэмжээний урсгал дансны алдагдалтай гарсан байна.

Зээл: Банкны салбарын зээл олголт хоёр шатлалт банкны тогтолцооны хөгжлийн эхэн үе буюу 1993-2000 онуудад харьцангуй бага хэмжээтэй өсөж байсан байна. 2001 оноос хойш банк санхүүгийн салбар тогтворжин эдийн засаг тэлж эхэлсэнтэй холбоотойгоор банкны салбарын нийт зээлийн үлдэгдлийн хэмжээ эрс нэмэгдэж тус онд олгосон зээлийн хэмжээ ДНБ-ий 4.3%-д хүрсэн байна.

Зураг 4. Зээл




Эх сурвалж: Монголбанк

Банкны салбарын тогтворжилтын үед (2001-2007) нийт зээлийн өрийн үлдэгдэл маш хурдацтай өсөж 2007 оны эцэст 2 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд тус онд олгосон зээлийн хэмжээ ДНБ-ий 11.1%-тай тэнцэж байв. Гэвч дэлхийн санхүү эдийн засгийн хямралаас шалтгаалсан зээлийн тасалдал бий болж 2008-2010 онуудын хооронд өсөлт нь огцом буурч 2009 онд нийт зээлийн өрийн үлдэгдлийн жилийн өсөлт 0.1 хувь болсон байна.

Эдийн засгийн халалтын үе буюу 2011-2013 онуудад нийт зээлийн жилийн дундаж хэмжээ ДНБ-ий 50% гаруй байсан бол 2015-2016 оны эдийн засгийн хүндрэлийн үед 5.1% болтлоо буурчээ. 2018 оны байдлаар нийт зээлийн өрийн үлдэгдэл 17.2 их наяд төгрөг байгаа нь ДНБ-ий 52.9%-тай тэнцэж байсан бол 2019 онд 18 их наяд төгрөг байгаа нь ДНБ-ий 47.8%-тай тэнцэж байна. 2020 онд 45.9%-тай, 2021 онд 47.9%-тай, 2022 онд нийт зээлийн өрийн үлдэгдэл нэмэгдэж 22.2 их наяд төгрөг байгаа нь ДНБ-ий 41.3%-тай тэнцсэн байна. Харин 2024 онд 45.9%-тэй тэнцэж байсан бол 2025 онд нийт зээлийн үлдэгдэл 44 их наяд төгрөг болж, ДНБ-ий 49%-тэй тэнцэж байна.

Гадаад өр: Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээ 2015 онд 22.7 тэрбум ам.доллар байсан бол 2025 оны III улирлын байдлаар 40.4 тэрбум ам.долларт хүрч 1.8 дахин өссөн бөгөөд энэ нь ДНБ-ий 160.3%-тай тэнцэж байна. Нийт гадаад өрнөөс гадаадын хөрөнгө оруулалттай компани хоорондын зээлийг хасаж үзвэл 2025 оны III улирлын байдлаар 22.1 тэрбум ам.доллар байна.

Зураг 5. Гадаад өр



Эх сурвалж: Монголбанк

3.3. Бенчмарк буюу жишиг утга

Khramov болон Lee (2013) нар индексийн тооцоонд орж буй үзүүлэлтүүдийн бенчмарк буюу жишиг утгыг сонгохдоо үзүүлэлт бүрийн оновчтой түвшнийг авч үзсэн байна. Ингэснээр улс орон бүр өөрийн онцлогт тохируулж үзүүлэлтүүдийн бенчмаркыг сонгох боломжтой болсон. Garry болон Francisco (2016) нар Латин Америкийн индексийн тооцоонд бенчмаркыг сонгохдоо үзүүлэлтүүдийн түүхэн дундаж утгыг ашигласан байна.

Монгол Улсын ЭЗГИ-ийн тооцоонд багтсан үзүүлэлтүүдийн бенчмаркыг Garry болон Francisco (2016) нарын судалгааны дагуу сонголоо. Бодит ДНБ-ий өсөлтийн бенчмаркыг потенциал үйлдвэрлэлийн түвшин байхаар сонгосон. Потенциал үйлдвэрлэлийн түвшинг хамгийн түгээмэл ашиглагддаг аргачлал болох Hodrick-Prescott шүүлтүүрээр тооцсон. Бодит ДНБ-ий өсөлтийн бенчмарк утгаасаа их байвал индексийн утгыг өсгөх чиглэлд тооцогдоно. Инфляцын бенчмарк утгыг Монголбанкны инфляцын зорилтот түвшин болох 6%-иар сонгосон бөгөөд жилийн дундаж инфляцын түвшин нь зорилтот түвшнээс давсан нөхцөлд индексийн утгыг бууруулах чиглэлд тооцогдоно.

Засгийн газрын санхүү болон гадаад секторыг төлөөлсөн үзүүлэлтүүд болох төсвийн тэнцэл болон урсгал дансны тэнцлийн хувьд бенчмарк утга нь 0 байхаар сонгосон. Хэрэв дээрх үзүүлэлтүүд сөрөг утгатай гарвал индексийн утга буурна, эерэг утгатай гарвал индексийн утга өсдөг. Санхүүгийн секторын үзүүлэлт болох банкны салбарын нийт зээлийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувийн жилийн өөрчлөлтийн бенчмаркыг сүүлийн 10 жилийн стандарт хазайлтын утгаар авсан. Нийт зээлийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувийн жилийн өөрчлөлтийн утга бенчмарк утгаасаа давсан тохиолдолд индексийн утгыг бууруулах чиглэлд тооцогдоно. Учир нь хэт их хэмжээний зээл олголт нь ирээдүйд эдийн засагт тэнцвэргүй байдлыг үүсгэдэг.

Гадаад өрийн бенчмаркыг сонгохдоо ОУВС-гийн шилжилтийн эдийн засагтай улс орнуудын гадаад өрийн тогтвортой байдлын босго утга болох гадаад өрийн ДНБ-д эзлэх

хувь 80% байхаар авсан. Хэрэв гадаад өрийн ДНБ-д эзлэх хувь энэхүү босго утгаас давбал индексийн утгыг бууруулах юм.

3.4. Эдийн засгийн гүйцэтгэлийн индекс

Монгол Улсын ЭЗГИ-ийг тооцох томъёог дээрх сонгосон үзүүлэлтүүд болон бенчмаркын утгуудыг ашиглан тэгшитгэл (4)-д харуулав.

$$MEPI = 100\% - w_{inf} |Inf(\%) - I^*| - w_{loan} \left| \Delta \frac{Loan}{GDP} (\%) - \Delta \frac{Loan^*}{GDP} \right| - w_{Def} \left(\frac{Def}{GDP} (\%) - \frac{Def^*}{GDP} \right) - w_{CA} \left(\frac{CA}{GDP} (\%) - \frac{CA^*}{GDP} \right) + w_{GDP} (\Delta GDP(\%) - \Delta GDP^*) \quad (4)$$


Энд: Inf – инфляц; $\Delta \frac{Loan}{GDP}$ – нийт зээлийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувийн жилийн өөрчлөлт;

$\frac{Def}{GDP}$ – төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь; $\frac{CA}{GDP}$ – урсгал дансны тэнцлийн ДНБ-д эзлэх хувь;

ΔGDP – бодит ДНБ-ий өсөлт; w_i – хувьсагч бүрийн хувийн жин; * - оор тэмдэглэсэн нь үзүүлэлтүүдийн бенчмарк.

Монголын Улсын ЭЗГИ нь эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг багтаасан нэгдсэн нэг үзүүлэлт бөгөөд энэхүү индексийг тооцож гаргаснаар олон нийт макро эдийн засгийн нөхцөл байдлын талаар ойлголттой болж, гүйцэтгэлийг нь хэмжих боломжтой болох юм. Түүнчлэн индексийн бүрэлдэхүүн бүрийн өөрчлөлтийг шинжлэх нь макро эдийн засгийн гүйцэтгэлд гарсан хэлбэлзлийн шалтгааныг задлан харах нэмэлт хэрэгсэл болдог байна. Монгол Улсын ЭЗГИ-ийг 1995-2025 он хүртэл жилийн давтамжтай тооцож үр дүнг Зураг 6-д харуулав.

Зураг 6. Эдийн засгийн гүйцэтгэлийн индекс



Эх сурвалж: Судлаачийн тооцоо


1995 оноос хойш Монгол Улсын ЭЗГИ нийт 31 жилийн хугацааны дунджаар 75.9 байгаа нь “D+” буюу “муу” гүйцэтгэлтэй гэсэн үр дүнтэй байна.

2025 оны байдлаар Монгол Улсын ЭЗГИ 97.3 гарсан ба ОУВС-гийн үнэлгээний дагуу “А” буюу “Маш сайн” гүйцэтгэлтэй гэсэн үр дүн гарлаа. Индексийн утга 2006 онд 118.5-д хүрч байсан нь эдийн засаг халалттай байсныг илтгэж байгаа бол 2020 онд хамгийн доод утга буюу 38.2%-д хүрч байжээ.

ЭЗГИ нь макро эдийн засгийн үзүүлэлт бөгөөд тухайн улсын эдийн засгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг хэмжиж, эдийн засгийн бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээний үр дүнг харуулах, зорилтот түвшнээс хазайх хазайлтыг мэдээлдэг хэмжигдэхүүн бөгөөд эдийн засгийн мөчлөг нь үнэлгээний утгаас шууд хамааралтай биш юм. Түүний зэрэгцээ өмнөх хугацаанд эдийн засгийн хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээ, гүйцэтгэлийг ЭЗГИ-ээр дүгнэж, өмнөх алдаа, дутагдлыг багасгаж, ирээдүйд оновчтой бодлого, арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байдаг.

Монгол Улсын ЭЗГИ-ийн 2001-2025 он хүртэлх динамикийг тооцоололд ашиглагдсан бүрэлдэхүүн үзүүлэлт тус бүрээр задлан Зураг 7-д харуулав.

Зураг 7. Эдийн засгийн гүйцэтгэлийн индекс, бүрэлдэхүүн үзүүлэлтээр



Эх сурвалж: Судлаачийн тооцоо

1997-2000 он: Монгол Улс 1990 оны эхэн үед зах зээлийн эдийн засагт шилжсэн бөгөөд шилжилтийн жилүүдэд эдийн засгийн нөхцөл байдал маш хүнд байсан. Эдийн засгийн өсөлт сөрөг, 3 оронтой буюу гиперинфляцтай байсан энэ үед ЭЗГИ “маш муу” гэсэн мужид байв. 1996-1998 онд инфляцын түвшин дунджаар 27.5% байсан нь индексийн утгыг бууруулахад нөлөөлж байсан.

2001-2003 он: 2000 оноос эдийн засгийн сэргэлт ажиглагдаж эхэлсэн ч Улсын төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь нэмэгдэж, дунджаар -7.2% болсон нь индексийн утгыг бууруулах гол хүчин зүйл болсон байна.

2003-2007 он: Энэ үед ЭЗГИ “сайн” үнэлгээтэй байжээ. 2001-2003 онд индекс өссөн ч төсөв болон урсгал дансны алдагдалтай үр дүн гарсан. 2003 оноос дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ өссөнөөр манай орны эдийн засгийн өсөлт нэмэгдэж, төсвийн орлого нэмэгдсэнээр алдагдал нь буурч, инфляцын хэлбэлзэл харьцангуй бага байсан нь индексийн утга сайжрах хүчин зүйлс болсон байна. Энэ үед индексийн бүрэлдэхүүн үзүүлэлтүүдийн жилийн дундаж утга нь бодит ДНБ өсөлт 8.7%, инфляц 8.2%, төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь 0.6%, урсгал дансны тэнцлийн ДНБ-д эзлэх хувь 3.1 %, банкны салбараас олгосон зээлийн ДНБ-д эзлэх хувь 30% байжээ. 2003 болон 2007 онуудад эдийн засгийн гүйцэтгэлийн индексийн утгад банкны салбараас олгосон зээлийн өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл голлон нөлөөлсөн байна.

2008-2009 он: Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын нөлөөгөөр манай улсын эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч, макро эдийн засгийн үзүүлэлтүүд огцом муудсан байна. Энэ үед эдийн засгийн гүйцэтгэлийн индексийн утга огцом буурч 66.6 буюу “муу” гэсэн мужид орсон байна. Индексийн бүрэлдэхүүн үзүүлэлтүүдийн хувьд бодит ДНБ-ий өсөлт -3.8%, инфляц 18%, төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь -4.9%, урсгал дансны тэнцлийн ДНБ-д эзлэх хувь -9.9%, банкны салбараас олгосон зээлийн ДНБ-д эзлэх хувь 40.2% болсон байна. Бодит ДНБ-ий бууралт, инфляц, урсгал данс болон төсвийн алдагдал голлон сөргөөр нөлөөлсөн байна.

2010-2014 он: ЭЗГИ “маш муу” мужид хэвээр байв. 2010 оноос дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ сэргэж манай улсад хийгдсэн их хэмжээний ГШХО болон ОУВС-гаас хэрэгжүүлсэн хөтөлбөрийн нөлөөгөөр эдийн засгийн өсөлтийг хурдасгасан байна. Улмаар 2011 онд эдийн засгийн өсөлт түүхэнд байгаагүй хамгийн өндөр түвшин буюу 17.3%-д хүрчээ. Гэтэл урсгал дансны алдагдал болон төсвийн алдагдал нь огцом өссөн, мөн банкны салбараас их хэмжээний зээлийг эдийн засагт нийлүүлж байсан нь индексийн утгыг бууруулах гол хүчин зүйл болж байжээ. Тухайн үед урсгал дансны алдагдлын ДНБ-д эзлэх хувь жилд дунджаар -30.6%, төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь жилд дунджаар -2.9%, банкны салбараас олгосон зээлийн ДНБ-д эзлэх хувийн өөрчлөлт жилд дунджаар 3.2% байжээ.

2015-2016 он: Энэ үед дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ унаснаар ГШХО зогсож, эдийн засгийн өсөлт удааширч эхэлсэн, мөн төсвийн алдагдал нэмэгдсэн нь ЭЗГИ “муу” гарахад нөлөөлсөн байна. 2016 онд бодит ДНБ-ий өсөлт 1.5% болсон бол төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь -15.3% болсноор Монгол Улсын ЭЗГИ “муу” үр дүнтэй гарсан байна.

2017-2019 он: Эдийн засагт сэргэлт ажиглагдаж, төсвийн алдагдал буурч, эдийн засгийн өсөлт тогтворжсоноор ЭЗГИ “дунд” гарсан. 2018 онд индексийн утга 93.6 буюу “дунд” мужид ороход бүрэлдэхүүн үзүүлэлтүүд болох бодит ДНБ-ий өсөлт 7.7%, инфляц 6.8%, төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь 2.6%, урсгал дансны тэнцлийн ДНБ-д эзлэх хувь -16.7%, гарсан нь нөлөөлжээ.

2020 он: Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөллөөр ЭЗГИ “маш муу” гарав. Үүнд бодит ДНБ-ий өсөлт -4.6%, төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь -9.2% гарсан нь голлон нөлөөлжээ.


2021-2024 он: Цар тахлын сөрөг нөлөөлөл багасаж, эдийн засгийн гүйцэтгэлийн индексийн утга нэмэгдэж, 2021 онд 77.5 буюу “муу”, 2022 онд 94.1 буюу “дунд”, 2023 онд 104.9 буюу “маш сайн”, 2024 онд 83.1 буюу “дунд” үнэлгээтэй гарлаа. 2021 онд урсгал данс болон

төсвийн алдагдал голлон сөргөөр нөлөөлсөн байна. 2022 онд урсгал дансны алдагдал эдийн засгийн гүйцэтгэлийн индекс буурахад голлон нөлөөлсөн байна. Эдийн засгийн өсөлт 2023 онд цар тахлын өмнөх үеийнхтэй ижил түвшинд буюу 7.4%, инфляцын түвшин 10.4%, төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь 2.7%, урсгал дансны тэнцлийн ДНБ-д эзлэх хувь 0.6%, банкны салбараас олгосон зээлийн ДНБ-д эзлэх хувийн өөрчлөлт -2.4% болсон байна. 2024 онд эдийн засгийн өсөлт 4.9%, инфляцын түвшин 6.8%, төсвийн тэнцэл -1.1%-тай, урсгал дансны тэнцэл -10.4%, нийт зээлийн ДНБ-д эзлэх хувь 7.1 нэгж хувиар нэмэгдсэн.

2025 он: Индексийн утга өмнөх оноос нэмэгдэж 97.3 хувь буюу “маш сайн” гарлаа. 2025 онд бодит ДНБ-ий өсөлт 6.8% гарсан нь индексийн утга нэмэгдэхэд голлон нөлөөлсөн байна. Мөн ДНБ-д урсгал дансны тэнцэл -4.5%, банкны салбараас олгосон нийт зээлийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувийн өөрчлөлт 3% болж саарсан байна. Харин инфляцын жилийн дундаж түвшин 8.6% буюу өмнөх оноос 1.8 нэгж хувиар өссөн, төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь -1.4% гарсан нь индексийн утгад сөргөөр нөлөөлсөн байна.

Монгол Улсын ЭЗГИ-ийг 2010 оноос 2025 он хүртэл нийт гадаад өрийн ДНБ-д эзлэх хувийг нэмэлт үзүүлэлт болгон оруулж алтернатив хувилбараар тооцсон үр дүнг Зураг 8-д харуулав.

Зураг 8. Эдийн засгийн гүйцэтгэлийн индекс (гадаад өрийг оруулсан)



Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Гадаад өрийг оруулж алтернатив хувилбараар тооцсон эдийн засгийн гүйцэтгэлийн индекс 84 буюу дундаж үнэлгээтэй гадаад өрийг оруулаагүй тооцсон үр дүнгээс 13.3 нэгж хувиар доогуур “дундаж” үнэлгээтэй гарлаа.

4. Дүгнэлт

Энэ судалгаа, шинжилгээний ажлаар Монгол Улсын эдийн засгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг макро эдийн засгийн гол үзүүлэлтүүд (бодит ДНБ-ий өсөлт, инфляц, төсвийн

тэнцэл, урсгал дансны тэнцэл болон банкны салбарын зээл)-ийг ашиглан ОУВС-гаас боловсруулсан аргачлалын дагуу индекс тооцож, гарсан үр дүнд шинжилгээ хийлээ. Түүнчлэн гадаад өрийн тоон мэдээллийг ашиглан ЭЗГИ-ийг алтернатив хувилбараар тооцож анх тооцсон индексийн үр дүнтэй харьцуулалт хийсэн.

Монгол Улсын ЭЗГИ-ийг 1995 оноос 2025 он хүртэл тооцсон бөгөөд индексийн бүрэлдэхүүн үзүүлэлт бүрээр задлан, үр дүнг нь эдийн засгийн үечлэлд хувааж шинжилгээг хийсэн. Эдийн засгийн тогтворжуулалтын жилүүд буюу 1993-2000 оны хооронд ЭЗГИ “маш муу” үнэлгээтэй гарахад төсвийн алдагдал, инфляцын түвшин өндөр байсан нь гол нөлөөг үзүүлж байжээ.

Харин эдийн засгийн сэргэлтийн жилүүд болох 2000-2007 онуудад ЭЗГИ “сайн” үнэлгээтэй байсан. Үүнд эдийн засгийн өсөлт нэмэгдсэн, төсвийн алдагдал буурч ашигтай гарсан, урсгал данс ашигтай гарсан, инфляц нам дор түвшин байсан зэрэг нь нөлөөлсөн байна.

Дэлхийн санхүү эдийн засгийн хямралын үед индекс огцом буурсан бол 2010 оноос манайд гадаадын шууд хөрөнгө оруулалтууд хийгдэж, уул уурхайн томоохон төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж эхэлснээр бодит ДНБ-ий өсөлт нэмэгдэж, төсвийн тэнцэл ашигтай гарснаар индексийн утга бага зэрэг дээшилж “дунд” мужид орсон байна.

Эдийн засгийн халалтын жилүүд буюу 2010-2013 онуудад эдийн засгийн өсөлт өндөр байсан ч урсгал дансны алдагдал болон төсвийн алдагдал өндөр түвшинд байсан нь индексийн утга муу гарах гол хүчин зүйл болж байв. 2011 онд бодит ДНБ-ий өсөлт өндөр байсан ч төсөв алдагдалтайгаас гадна урсгал дансны алдагдал өндөр байж индексийн утга хамгийн доод буюу 36.1 болж F буюу “маш муу” байсантай адил 2016 оны эдийн засгийн хүндрэлийн үед төсвийн тэнцэл түүхэнд хамгийн их алдагдалтай байсан нь индексийн утга 53.1 буюу “маш муу” гарсан байна.

2017 оны эцсээр эдийн засаг сэргэж эхэлснээр төсвийн алдагдал буурч, ДНБ-ий өсөлтийн хурд нэмэгдсэнээр индексийн утга өсөж 2018-2019 онд “сайн” үнэлгээтэй гарч байв.

Харин 2020 онд цар тахлын хямралын үед эдийн ЭЗГИ “муу” үнэлгээтэй гарсан нь төсвийн тэнцэл 3.4 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан, хил гааль хаагдаж эдийн засгийн идэвхгүй орчин нөхцөл нөлөөлсөн.

2022 оноос эдийн засаг аажмаар сэргэж тус индекс 2023 онд ДНБ-ий өсөлт 7.4%-тай, урсгал данс ашигтай гарч, төсвийн тэнцэл түүхэнд дээд буюу 1.8 их наяд төгрөгийн ашигтай гарсан зэрэг нөлөөлж 107.3 буюу “маш сайн” үнэлгээтэй гарсан.

ЭЗГИ-ийн бүрэлдэхүүн үзүүлэлтүүдийн урьдчилсан тоон мэдээллээр 2024 онд инфляц зорилгод түвшинд хадгалагдаж, төсвийн тэнцэл ашигтай гарсан хэдий ч эдийн засгийн өсөлт 4.9% болж өсөлтийн хурд бууран, урсгал дансны алдагдал 2.2 тэрбум долларын алдагдалтай гарсан зэрэг нөлөөлж, эдийн засгийн гүйцэтгэл 83.1% буюу “дунд” үнэлгээтэй гарсан.

Харин 2025 онд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг 33.2%, үйлдвэрлэл, барилгын салбарынх 11.4%, уул уурхай, олборлолт 10.6%-аар нэмэгдсэн нь бодит ДНБ-ий өсөлтөд голлон нөлөөлж 6.8% болсон, урсгал дансны алдагдал буурсан нь индексийн утга нэмэгдэхэд голлон нөлөөлж 97.3% гарлаа. Энэ нь үзүүлэлт нь макро эдийн засгийн нийт гүйцэтгэл мэдэгдэхүйц сайжирч байгааг харуулж байгаа бөгөөд энэ нь өмнөх тогтворгүй байдлын үеүдийн дараа эдийн засгийн сэргэлт, тэлэлт үргэлжилсээр байгааг харуулж байна.

Түүнчлэн барааны худалдааны ашиг 36.1% өсөж, үйлчилгээний худалдааны тэнцлийн алдагдал 14.2% буурсан нь урсгал дансны алдагдал өмнөх оноос буурахад голлон нөлөөлж, санхүүгийн нөхцөл байдал харьцангуй тогтворжиж байна. Эдгээр үр дүнд хэд хэдэн салбарын эдийн засгийн үйл ажиллагаа аажмаар сэргэж, улмаар индексийн өсөлтийг бэхжүүлсэн.

Гэвч ЭЗГИ-ийн үр дүн нь макро эдийн засгийн зарим үзүүлэлтүүдийн эмзэг байдлыг хэвээр байгааг харуулж байна. Гадаад өр өндөр түвшинд хадгалагдсаар байгаа нь эдийн засгийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх эрсдэл байсаар байгаа нь судалгааны үр дүнгээс харагдлаа. Мөн инфляцын дарамт хэвээр байгаа нь дотоодын эрэлтийн хүчин зүйлс болон гадаад шокийн нөлөөллөөс үүдэлтэй гэж үзэж байна. Түүнчлэн, түүхий эдийн экспортоос хамааралтай хэвээр байгаа нь дэлхийн түүхий эдийн үнийн хэлбэлзэл, эрэлтийн нөхцөл байдал зэрэг гадаад шоккод өртөх магадлалтай байна. 2025 онд индексийн утга өссөн ч макро эдийн засгийн сорилтуудтай тулгарч байна. Цаашид эдийн засгийг тогтворжуулах, төрөлжүүлэх, гадаад шокийн нөлөөнд тэсвэртэй байдлыг бэхжүүлэх чиглэлээр анхаарч бодлого боловсруулах нь оновчтой гэж үзэж байна.

Ашигласан материал

- Abel, Andrew and Ben Bernanke (2005) *Macroeconomics* (5th ed.) Pearson.
- Allida Black, June Hopkins, et. al. (2003) *Teaching Eleanor Roosevelt. The Eleanor Roosevelt Papers.* Dwight Eisenhower. Hyde Park, New York: Eleanor Roosevelt National Historic Site.
- Balke, Nathan S. and Robert J. Gordon (1989) *The Estimation of Prewar Gross National Product: Methodology and New Evidence.* *Journal of Political Economy* 97, 38–92.
- Ball, Laurence and Gregory Mankiw (2002) *The NAIRU in theory and practice.* *The Journal of Economic Perspectives*, Volume: 16, issue: 4, 115-136.
- Barro, Robert J. (1997) *Macroeconomics*, Cambridge, Mass: MIT Press, 895.
- Burns, A.F. and Mitchell, W.C. (1946) *Measuring business cycles.* NBER Studies in Business Cycles No. 2, New York.
- Chari, V.V., L.J. Christiano, and P.J. Kehoe (1993) *Optimality of the Friedman rule in economies with distorting taxes,* Research Department staff report 158 (Federal Reserve Bank of Minneapolis).
- Diebold, F.X. and Rudebusch, G.D. (1991b) *Forecasting output with the composite leading index: A real-time analysis.* *Journal of the American Statistical Association* 86, 603–610.
- Diebold, F.X. and Rudebusch, G.D. (1991a) *Turning point prediction with the composite leading index: An ex-ante analysis.* In: Lahiri, K., Moore, G.H. (Eds.) *Leading Economic Indicators: New Approaches and Forecasting Records.* Cambridge University Press, Cambridge, UK, 231–256
- Hodrick, Robert, and Edward C. Prescott (1997) *Postwar U.S. Business Cycles: An Empirical Investigation.* *Journal of Money, Credit, and Banking*, Vol. 29, 1-16.
- Vadim Khramov & John Ridings Lee, 2013. "The Economic Performance Index (ЭЗГИ); an Intuitive Indicator for Assessing a Country's Economic Performance Dynamics in an Historical Perspective," IMF Working Papers 13/214, International Monetary Fund.